



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Л.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.07.16

№

04

Төрийн албаны зөвлөлийн хууль
тогтоомж хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

Төрийн албаны зөвлөлийн хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн дараах ажлын тоо, мэдээллийг 2020-2024 оны эхний хагас жилийн байдлаар бэлтгэн хуулийн хугацаанд ирүүлнэ үү. Үүнд:

1.Төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд тавьсан хяналт, шалгалт, хууль тогтоомж зөрчиж сонгон шалгаруулалт явуулсан, төрийн албан хаагчийг томилсон нь тогтоогдсон бол зөрчлийг арилгахаар өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, түүний биелэлт, хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нөхцөл;

2.Иргэн, байгууллага, албан хаагчийн гомдол, мэдээллийн дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаанд хийсэн шалгалт, илэрсэн зөрчлийг арилгахаар хүргүүлсэн хугацаатай шаардлага, хууль тогтоомж зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээний биелэлт;

3.Төрийн албан хаагчийн хувийн хэрэг, тоо бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох ажлын хэрэгжилт;

4.Төрийн албаны төв байгууллагын болон шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, биелүүлсэн боловч албан хаагчийг хууль бусаар дахин ажлаас халсан албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгох, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг эрх бүхий этгээдэд хүргүүлсэн болон түүний биелэлт, биелэхгүй байгаа шалтгаан нөхцөл;

5.Төрийн албаны хууль тогтоомж зөрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсныг тогтоосон байдал, энэ чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг болно.

2024000015

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АЛТАНГЭРЭЛ

2024000019